



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/557

Есөнбулаг

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1. дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 2022/53 дугаар гэрээтэй Есөнбулаг сумын 1,5 км цэвэр усны шугам сүлжээний шинэчлэлтийн ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитектор)
Гишүүдэд:	М.Мандаххүү	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	Н.Долгорсүрэн	("Барилгын хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн бүс хариуцсан ахлах инженер)
	С.Энхбаяр	(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад)
	Г.Золзаяа	(Эрүүл мэндийн газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч)
	Б.Батбилэг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч)
	Ж.Билэгсайхан	(Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн)
	Д.Нямжаргал	(Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын Захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн)

- Г.Хүрэлхүү ("Ундарга-Алтай" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий инженер) (хангагч)
- Д.Байгальмаа ("Ундарга-Алтай" ААТҮГ-ын ашиглалтын инженер) (хангагч)
- Ж.Наранцэцэг ("Санни сервес" ХХК-ийн гүйцэтгэх захирал) (зохиогч)
- Б.Даваажаргал ("Өгөөмөрбаян булаг" ХХК-ийн захирал) (гүйцэтгэгч)
- Нарийн бичгийн дарга: М.Мөнхцэцэг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженерийн барилга байгууламж хариуцсан мэргэжилтэн)

2.Инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдэлтэй нийцүүлэн шалгаж, хүлээн авч, үр дүнг танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Холбогдох акт, баримт бичгийг үндэслэн орон нутгийн өмчид бүртгэхийг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), барилга байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгаж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг "Ундарга-Алтай" ААТҮГ (Г.Хүрэлхүү)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ